

2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

**ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ХУВЬ  
ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД**

**Шинжээч сонгон шалгаруулах урилга хүргүүлэх тухай**

Үндэсний аудитын газар нь “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит”-ын гүйцэтгэлийн болон тайлagnalын үе шатны ажилд “Байгаль орчны чиглэлийн нарийн мэргэжлийн дэмжлэг, туслалцааг аудитын багт үзүүлэх” шинжээч сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу хэрэгжих бөгөөд сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Шинжээчийг сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:

- Ажлын даалгавар
- Саналын баримт бичиг

Шинжээч нь **ҮАГ-АД/22-034** дугаар ажлын даалгаварт заасан ажлыг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу АДБОУС, холбогдох журам болон бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн “Тосон Уул XIX”, “Тамсаг XXI” /Дорнод аймгийн Матад, Халхгол сум/-д тус тус ажиллаж, бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан тайлан бичиж, дүгнэлт гарган холбогдох баримт бичгийг гэрээ байгуулан ажилласнаас 50 хоногийн хугацаанд багтаан аудитын багт хүлээлгэн өгнө.

Сонирхсон этгээд нь Ажлын даалгавар, “Шинжээч сонгох саналын баримт бичиг” бусад холбогдох мэдээллийг [www.audit.mn](http://www.audit.mn) цахим хаягаас болон ҮАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюушаас авч болно. Ажлын утас: 51-261745, гар утас: 88051068.

Саналыг файл хэлбэрээр [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn), [tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn) цахим шуудангаар 2022 оны 12 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү.

Захиалагчийн хаяг: Үндэсний аудитын газар-15160. Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.



(Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Петровчайна Дачин Тамсаг ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх) АУДИТ

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 11 дугаар сарын  
25.-ны өдөр

Дугаар 44-А8  
12-024

Улаанбаатар  
хот

**Ажлын зорилго:** Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулдаг Петровчайна Дачин Тамсаг ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажилд байгаль орчны чиглэлийн нарийн мэргэжлийн дэмжлэг, туслалцааг аудитын багт үзүүлж, хамтран ажиллана.

**Ажил гүйцэтгэх хугацаа:** 2022.12.12-2023.02.15

**Байршил:** Үндэсний аудитын газар

### НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газар (цаашид захиалагч гэх) Петровчайна Дачин Тамсаг ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит хийж баталгаажуулна.

### ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээч нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг АДБОУС, холбогдох журам болон бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Петровчайна Дачин Тамсаг ХХК-ийн "Тосон Уул XIX", "Тамсаг XXI" /Дорнод аймгийн Матад, Халхгол сум/-д тус тус ажиллана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатанд дараах АДБОУС, холбогдох журам болон бусад баримт бичигт гүйцэтгэн, тайлан ирүүлнэ. Үүнд:

- Гэрээлэгчийн 2020-2021 онд төлөвлөсөн байгаль орчны нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодитой боловсруулж, хянаж, баталсан эсэхэд нотлох баримттай, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;

- Байгаль орчны ажлын төлөвлөлтөд тусгасан өрмийн хаягдал шингэнийг саармагжуулах, технологийн хаягдал буюу тостой бохир шороог цэвэршүүлэх, хатуу хог хаягдлын цэгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн нөхөн сэргээлтийг хийсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- Хөрсний дээж авалт, лабораторийн шинжилгээ, биологийн нөхөн сэргээлт, олборлоптын талбай буцаалтын байгаль орчны нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу хийсэн эсэхэд нотлох баримттай, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;
- Гэрээлэгчийн 2020-2021 онд байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан зардал бодитой, үнэн зөв эсэхийг холбогдох тайлан, баримтад тулгуурлан, үйлдвэрлэлийн бааз болон газар дээр нь очиж, тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах;

## ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хамрах хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн “Тосон Уул XIX”, “Тамсаг ХХI” талбайн 2020-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээнд байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.

## ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Зөвлөхийн ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

Аудитын үе шат	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй үр дүн
Гүйцэтгэлийн үе шат	<ol style="list-style-type: none"> <li>Гэрээлэгчийн 2020-2021 оны байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан өртөг нөхөх зардлын задаргааг он тус бүрээр ангилаа.</li> <li>Өрмийн хаягдал шингэнийг саармагжуулах, технологийн хаягдал буюу тостой бохир шороог цэвэршүүлэх, хатуу хог хаягдлын цэгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн нөхөн сэргээлт хийсэн эсэхэд дүгнэлт гаргана.</li> <li>Байгаль орчны үнэлгээний ажил болон байгаль орчны хяналт шинжилгээ хийсэн эсэх, хөрсний дээж авалт, авсан дээжийн лабораторийн шинжилгээ, биологийн нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу хийсэн эсэхэд дүгнэлт гаргана.</li> <li>Гэрээлэгчийн 2020-2021 оны байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулсан ажлын тайланг бичгээр ирүүлнэ.</li> </ol>	Гэрээлэгчийн 2020-2021 оны Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгасан ажлын бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, ажлын тайлан ирсэн байна.
Тайлагнальын үе шат	<ol style="list-style-type: none"> <li>Аудитын тайлангийн төсөл боловсруулахад оролцох, асуудлын шинжилгээний бүлгийн дагуу бичсэн дэд тайлангууд болон нэгдсэн тайланда мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө. /Шалгагдагч байгууллагын санал мөн хамаарна/</li> <li>Тайланг Аудитын зөвлөл, УИХ-ын Төсвийн байнгын хороогоор хэлэлцэхэд аудитын багт зөвлөмж өгч оролцох.</li> </ol>	Дэд болон нэгтгэсэн тайлангийн төсөл боловсруулсан байна.

## ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд оролцох Зөвлөх /иргэн, хуулийн этгээд, баг байж болно/ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Петровчайна Дачин Тамсаг ХХК-ийн “Тосон Уул XIX”, “Тамсаг XXI” талбайн 2020-2021 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг гүйцэтгэхэд Үндэсний аудитын газрын аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээч нь ажил эхлүүлэх болон хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэн захиалагч /Үндэсний аудитын газар-/тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх явцад шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

### **ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА**

Зөвлөх шинжээч нь байгаль орчны чиглэлээр ажлын дадлага, туршлагатай, дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан, тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна.

Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хувь хүн байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөхэд дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

#### **Хуулийн этгээдийн хувьд:**

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг; Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - Байгаль орчны чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй;
  - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байх;
  - Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж байсан туршлагатай;
  - Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
  - Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;
  - Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
  - Тухайн мэргэжлийн чиглэлээр 10-оос доошгүй жил ажилласан байх;

#### **Ажиллах хүчний шаардлага:**

- Байгаль орчны чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байсан туршлагатай;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Багаар ажиллах, ачаалал даах чадвартай;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

#### **Баг, хувь хүний хувьд:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);

- Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

### **ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно. гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

#### **Хянасан:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

 Н. НАРАНЧИМЭГ

 Д.ОТГОНБАЯР

#### **Боловсруулсан:**

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

 Б.АНХБААТАР

 Ц.БАТСҮХ

 Ц.ЦЭРЭННАМЖИЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



"ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР  
ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ  
ХХК-ИЙН 2020-2021 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ДАГУУ ХИЙЖ  
ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХСӨН БОЛОН  
НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН  
ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ АУДИТ"-ЫН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН БОЛОН ТАЙЛАГНАЛЫН ҮЕ ШАТНЫ АЖИЛД  
"БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛИЙН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ДЭМЖЛЭГ,  
ТУСЛАЛЦААГ АУДИТЫН БАГТ ҮЗҮҮЛЭХ"  
ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

УЛААНБААТАР ХОТ

2022 он

## БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 10-ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

## САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: [Захиалагч нь: Үндэсний аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.]
2	<p>Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж:</p> <p>Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй шинжээчийн баг, хуулийн этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба тус газрын Аудитын гуравдугаар газрын аудитын багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.</p> <p>Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, териийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.</p> <p>Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.</p>
3	Шинжээчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай эсэх: “үгүй”
4	Санал хүлээн авах хугацаанаас 2 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө.
5	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон шинжээч эсхүл хуулийн этгээд мөн жагсаалтад орсон бусад компанийн хамтран ажиллаж болно: “хамааралгүй”
7	Шинжээчийн ажил үйлчилгээ ажлын даалгаварт тусгасан өдөрт багтаан гүйцэтгэнэ.
8	<p><u>Гүйцэтгэх ажлын үнийн санал</u></p> <p>Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: 10 560 000 /арван сая таван зуун жаран мянган/ төгрөг байна.</p> <p>Шинжээчийн ажлыг гүйцэтгэх гэж буй зөвлөх нь ҮНЭ-ийг санал болгоходоо ажлын даалгаварт тусгагдсан ажилбар тус бүрийг тооцоолж, саналаа ирүүлэх шаардлагатай.</p> <p style="text-align: center;"><b>ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ</b></p> <p>Байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээч нь аудитын багтай хамтран тайлан ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>Гэрээлэгчийн 2020-2021 онд төлөвлөсөн байгаль орчны нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодитой боловсруулж, хянаж, баталсан эсэхэд нотлох баримттай, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;</li> <li>Байгаль орчны ажлын төлөвлөлтөд тусгасан өрмийн хаягдал шингэнийг саармагжуулах, технологийн хаягдал буюу тостой бохир шороог цэвэршүүлэх, хатуу хог хаягдын цэгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн шингэн хаягдын сангийн нөхөн сэргээлтийг хийсэн эсэхэд дүгнэлт гаргах;</li> <li>Хөрсний дээж авалт, лабораторийн шинжилгээ, биологийн нөхөн сэргээлт, олборлолтын талбай буцаалтын байгаль орчны нөхөн сэргээх ажлыг холбогдох</li> </ol>

	<p>хууль тогтоомж, стандартын дагуу хийсэн эсэхэд нотлох баримттай, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;</p> <p>4. Гэрээлэгчийн 2020-2021 онд байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан зардал бодитой, үнэн зөв эсэхийг холбогдох тайлан, баримтад тулгуурлан, үйлдвэрлэлийн бааз болон газар дээр нь очиж, тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах;</p> <p style="text-align: center;"><b>АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ</b></p> <p>Аудитын хамрах хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн “Тосон Уул XIX”, “Тамсаг ХХI” талбайн 2020-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээнд байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.</p>
	<p>Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх, шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах үндсэн мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ. Үүнд:</p> <p>Хуулийн этгээд бол:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>- Татварын өргүй тухай тодорхойлолт;</li> <li>- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт;</li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;</li> <li>- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;</li> <li>- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;</li> <li>- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.</li> </ul> <p>Хувь хүн/баг бол:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэний үнэмлэхийн хуулбар;</li> <li>- Анкет /CV/;</li> <li>- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;</li> <li>- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ ирүүлэх /нотариатжуулсан/:</li> </ul> <p><b>Мөн баримт бичигт хавсаргасан дараахь маягтаар саналаа илэрхийлсэн байна. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Оролцох хүсэлтийн маягт. /Маягт 2/</li> <li>- Оролцогчийн танилцуулга. /Маягт3/</li> <li>- Санал болгож буй мэргэжилтний намтар(CV). /Маягт 4/</li> <li>- Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж. /Маягт 5/</li> <li>- Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт. /Маягт 6/</li> <li>- Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга /Маягт 7/</li> </ul> <p><b>Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:</b></p> <p>Зөвлөх шинжээч нь байгаль орчны чиглэлээр ажлын дадлага, туршлагатай, дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан, тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна.</p>
9	

Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хувь хүн байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөхөд дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Байгаль орчны чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байх;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж байсан туршлагатай;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;

• Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;

• Тухайн мэргэжлийн чиглэлээр 10-оос доошгүй жил ажилласан байх;

Ажиллах хүчний шаардлага:

• Байгаль орчны чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;

• Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан;

• Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байсан туршлагатай;

• Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;

• Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;

• Багаар ажиллах, ачаалал даах чадвартай;

• Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

Баг, хувь хүний хувьд:

• Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;

• Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;

• Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;

• Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);

• Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ.

10 Шинжээчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.

Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага.

11 Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

12 Татвар [Гүйцэтгэгч, тэдгээрийн ажиллах хүчин нь холбогдох хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой. Иймд гэрээт ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг ажил олгогчийн зүгээс суутган тооцно.]

Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан төлбөрийн хуваарийн дагуу цахим төлбөрийн баримтын системд төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн үед төлбөрийг шилжүүлнэ]:

13 Санал ирүүлэх тоо: эх хувь 1

14 Санал ирүүлэх хаяг: Цахимаар

	Үндэсний аудитын газар. Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068.
15	Саналыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлсэн байна.
16	(а) Төсөвт өртөг нь 50 сая ба түүнээс дээш өртөгтэй тул ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа шаардана. (б) Гүйцэтгэлийн баталгааг зохих маягтын дагуу гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх бөгөөд гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь санал болгосон үнэ буюу гэрээний үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна. Гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

## МАЯГТ 2

### ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г \_\_\_\_\_ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцоололыг хавсарган/

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: \_\_\_\_\_

Холбоо барих утас: \_\_\_\_\_

## ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

## 3.1. Ерөнхий танилцуулга

(Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.

Гүйцэтгэсэн ажлын нэр:	Улсын нэр:		
Байршил:	Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):		
Захиалагчийн нэр:	Ажилтны тоо:		
Хаяг:	Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:		
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Aжлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:	
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:	
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:			
Төслийн талаарх товч танилцуулга:			
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:			

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: \_\_\_\_\_

## САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Үр чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай ]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муюу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

МАЯГТ 5

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ<sup>1</sup>

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

МАЯГТ 6

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

МАЯГТ 7

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ. Үүнд:
- 

№	Хийх ажилбар	Хэрэгжүүлэх хугацаа					Хариуцах ажилтан
		...	...			гэх мэт	

- Ажил гүйцэтгэх аргачлалыг ажлын даалгаврыг үндэслэн дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

Баталгаажуулах

<sup>1</sup> Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.